



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цогтцэций сумын “Тэгш Дүүрэн” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2022/34/-НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас:
www.umnugovi@audit.gov.mn

Даланзадгад сум
2022 он

Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор:
С.Цэрэнбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК
Утас: 77270808 Цахим хаяг: nitsbalance@gmail.com

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6-7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	8
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	9
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	10-13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	10
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
8. Аудитын илрүүлэлт.....	14
8.1 Залруулсан алдаа.....	11
8.2 Төлбөрийн акт	11
8.3 Албан шаардлага.....	11
8.4 Зөвлөмж.....	15-16
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17-18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал Хувьцаат Компани
АОУС	Аудитын олон улсын стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмүү өртгийн албан татвар
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар

1.Аудитын санал дүгнэлт



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2022.03.15 № 276
танай _____ -ны № _____ -т

ЦОГТЦЭЦИЙ СУМЫН
“ТЭГШ ДҮҮРЭН” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Л. ЭНХЖАРГАЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цогтцэций сумын “Тэгш дүүрэн” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Тус байгууллагын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Цогтцэций сумын “Тэгш дүүрэн” ОНӨААТҮГ нь 2021 онд үр дүнгийн гэрээ байгуулж, бизнес төлөвлөгөө батлуулаагүй байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээллээс тусдаа санхүүгийн ба санхүүгийн бус мэдээлэл байхгүй байна. Санхүүгийн тайланд өгсөн бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

016021428

Цогтцэций сумын “Тэгш дүүрэн” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

D:\2021 Он\Бичиг Хэрэг\Явсан Бичиг\2022-03-15 №276с

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
2	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	20,751,402.47	24,411,078.90
3	Дансны авлага	3,594,280.00	4,238,106.06
4	Бараа материал	6,799,954.54	9,120,000.04
5	Эргэлтийн хөрөнгийн дүн	31,145,637.01	37,769,185.00
6	Үндсэн хөрөнгө	427,835,672.16	362,637,386.35
7	Биет бус хөрөнгө	66,666.74	-
8	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	427,902,338.90	362,637,386.35
9	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	459,047,975.91	400,406,571.35
10	Цалингийн өглөг	-	148,311.00
11	Татварын өр	1,277,038.72	-
12	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,277,038.72	148,311.00
13	Бусад урт хугацаат өглөг	419,979,923.68	353,934,762.76
14	Урт хугацаат өр төлбөрийн дүн	419,979,923.68	353,934,762.76
15	Өр төлбөрийн нийт дүн	421,256,962.40	354,083,073.76
16	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,785,860.10	5,785,860.10
17	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	32,005,153.41	40,537,637.49
18	Эздийн өмчийн дүн	37,791,013.51	46,323,497.59
19	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	459,047,975.91	400,406,571.35

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	241,362,168.75	226,988,242.62
2	Борлуулалтын өртөг	182,362,168.75	199,064,872.69
3	Нийт ашиг	58,999,045.09	27,923,369.93
4	Бусад орлого	137,034,333.57	137,569,362.29
5	Ерөнхий ба удирдлагын зардал	176,060,220.15	154,279,490.64
6	Санхүүгийн зардал	864,000.00	1,740,000.00
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	17,117,314.98	8,532,484.08
8	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	19,109,158.51	9,473,241.58
9	Орлогын татварын зардал	1,991,843.53	940,757.50
10	Татвар дараах ашиг (алдагдал)	17,117,314.98	8,532,484.08
11	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	17,117,314.98	8,532,484.08

Цогтцэций сумын “Тэгш дүүрэн” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	5,785,860.10	32,005,153.41	37,791,013.51
2	Залруулсан үлдэгдэл	-	-	-
3	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	-	8,532,484.08	8,532,484.08
4	2021 оны 12- р сарын 31-ний үлдэгдэл	5,785,860.10	40,537,637.49	46,323,497.59

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Мөнгөн орлогын дүн (+)	340,755,639.45	330,767,597.80
2	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	171,553,147.06	128,861,999.91
3	Бусад мөнгөн орлого	168,962,492.39	201,905,597.89
4	Мөнгөн зарлагын дүн (-)	322875103.7	327,107,921.37
5	Ажиллагчдад төлсөн	134,160,476.41	123,729,890.15
6	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	42,708,908.00	41,509,459.25
7	Бараа материалын худалдан авахад төлсөн	50,069,000.17	77,830,676.02
8	Ашиглалтын зардалд төлсөн	13,698,398.86	607,900.00
9	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	37,882,339.04	35,916,438.00
10	Хүүний төлбөрт төлсөн	-	-
11	Татварын байгууллагад төлсөн	40,473,155.20	43,471,663.97
12	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
13	Бусад мөнгөн зарлага	3,642,826.00	4,041,893.98
14	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	17,880,535.77	3,659,676.43
15	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	17,880,535.77	3,659,676.43
16	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,870,866.70	20,751,402.47
17	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,751,402.47	24,411,078.90

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 он			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Орлого нэр төрлөөр	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт					
	Татаас санхүүжилт	137,034,300	136,363,600	136,650,000	(286,400)	100
	Хүнд даацын тээврийн авто машин түр хоноглох байр	47,876,900	62,181,800	52,218,000	9,963,800	84
	Дуудлагын хог хаягдлын орлого	123,223,200	123,272,700	107,968,700	15,304,000	86
	Түрээсийн орлого	4,970,600	7,127,200	2,430,200	4,697,000	35
	Барилгын гэрээний орлого	65,290,300	66,045,100	66,045,100	-	100
Нийт орлогын дүн		378,395,300	394,990,400	365,312,000	(29,678,400)	92
Үүнээс: Цэвэр Борлуулалт		241,361,200	277,885,100	226,988,200	(50,896,900)	82
Нийт зардал		359,287,300	388,920,200	355,150,000	(33,770,200)	91
Зардлын төрлөөр	ББӨ	182,363,100	199,064,800	199,064,800	-	100
	Ерөнхий ба удирдлагын зардал	176,924,200	188,526,500	156,019,000	(32,507,500)	83
	Борлуулалтын зардал					
Цэвэр ашиг алдагдал		17,117,300	6,070,200	8,532,400		
Нийт ашиг алдагдал		17,117,300	6,070,200	8,532,400		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цогтцэций сумын “Тэгш дүүрэн” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж, аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллагын дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад авлага, өглөгийн дансанд болон цалингийн зардал, төлөвлөлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-аас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-ийн ахлах аудитор Ц.Энхтуяа гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, дараагийн шатны хяналтыг Төрийн аудитын газрын аудитын менежер Т.Хонгорзул, дарга, тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайланг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Цогтцэций сумын “Тэгш дүүрэн” ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж,

гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Цогтцэций сумын “Тэгш дүүрэн” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт борлуулалтын орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн борлуулалтын орлого 227.0 сая төгрөгийн 2.0 хувь буюу 4.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 3.1 сая төгрөгөөр тус тус тогтоов.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Цогтцэций сумын “Тэгш дүүрэн” ОНӨААТҮГ-ын зорилгоо “ Аюулгүй ажиллагааг эрхэмлэн, сум орон нутагт эрүүл, цэвэр орчныг бүрдүүлж, чанартай үйлчилгээг иргэдэд хүргэж, орон нутгийн хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах” гэж тодорхойлсон байна.

Цогтцэций сумын “Тэгш дүүрэн” ОНӨААТҮГ нь дараах үндсэн чиглэлүүдээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

- Хог хаягдлын менежмент
- Нийтийн эзэмшлийн замын арчилгаа, цэвэрлэгээ
- Ногоон байгууламжийн усалгаа арчилгаа
- Ахуйн үйлчилгээний алба

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай ба өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Тэгш дүүрэн” ОНӨААТҮГ нь Цогтцэций сумын ИТХ-ын 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 15 тоот тогтоолын дагуу үүсгэн байгуулагдсан байна.

“Тэгш дүүрэн” ОНӨААТҮГ-ын захирлын тушаалаар 2021 оны бүтэц орон тооны хувьд 34 ажилтантай байхаар батлагдсан бөгөөд 2021 оны 12 дугаар сарын байдлаар 18 хүний бүрэлдэхүүнтэй, 8 техниктэй ажилласан байна.

МУЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3-д: “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, 3 орон тоог хэмнэн чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх зардлыг гаргахгүй байх” гэж заасантай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- МУЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д: “Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана” /2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/;
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор баталсан “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах тухай”.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Цогтцэций сумын “Тэгш дүүрэн” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	20.7	24.4	3.7
Авлага	3.6	4.2	0.6
Бараа материал	6.8	9.1	2.3
Урьдчилж төлсөн зардал/тооцоо			
Үндсэн хөрөнгө	427.9	362.6	(65.3)
Биет бус хөрөнгө	0.06	0.0	(0.06)
Нийт хөрөнгө	459.0	400.4	(58.6)
Богино хугацаат өр төлбөр	1.3	0.1	(1.2)
Бусад урт хугацаат өр төлбөр	420.0	3539	(66.1)
Эздийн өмч /Төрийн өмч/	37.8	46.3	8.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	459.0	400.4	(58.6)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 24.4 сая төгрөг болж, өмнөх оноос 3.7 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант хугацааны мөнгөн урсгалын хөдлөл, өөрчлөлттэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 4.2 сая төгрөг болж, өмнөх оноос 0.6 сая төгрөгөөр өссөн нь ААН байгууллагаас авах авлага барагдуулаагүйтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 9.1 сая төгрөг болж, өмнөх оноос 2.3 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант оны бараа материалын орлого, зарлагын хөдлөл өөрчлөлттэй холбоотой байна. Тухайлбал: Тайлант хугацаанд нийт 70.1 сая төгрөгийн бараа материал худалдан авсан ба 67.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 362.6 сая төгрөг болж, өмнөх оноос 65.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардлаас голлон шалтгаалсан байна.

Богино хугацаат өр төлбөрийн дансны 0.1 сая төгрөгийн үлдэгдэл болж, өмнөх өмнөх өглөгийг барагдуулсантай холбоотой байна.

Бусад урт хугацаат өр төлбөр 66.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардлаар орлогод хүлээн зөвшөөрч буй хөрөнгөтэй холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 400.4 сая төгрөг болж 58.6 сая төгрөгөөр өссөн нь тайлан үеийн элэгдлийн зардалтай холбоотой байна.

4.4. ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Цогтцэций сумын “Тэгш дүүрэн” ОНӨААТҮГ нь бизнес төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Цогтцэций сумын Засаг даргатай “Тэгш дүүрэн” ОНӨААТҮГ-ын захирал 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг батлуулж ажиллаагүй байна.

Нийт орлогын гүйцэтгэл 365.3 сая төгрөг болж төлөвлөснөөс 29.6 сая төгрөг буюу 7.9 хувиар буурсан нь корона /ковид19/ цар тахалтай холбоотой зарим үйл ажиллагааны цар хүрээ хумигдсантай холбоотой байна.

Тайлант онд борлуулсан бүтээгдэхүүний өртөг өмнөх оноос 50.9 сая төгрөгөөр буурсан бол төлөвлөснөөс 18.4 хувиар буурсан байна. Энэ нь зарим урсгал зардлын хэмнэлт болон үйл ажиллагааны хэмжээ буурснаас голлон шалтгаалсан байна.

Тайлант оны нийт ашиг 8.5 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 2.4 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т: “хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх” зохицуулалттай байна.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Shilendans.gov.mn цахим хуудсанд 146 мэдээлэл байршуулахаас тухай бүр 1, улирал бүр 1 нийт 2 мэдээлэл хоцроож, бүтэн жил 2 мэдээллийг тус тус байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Цогтцэций сумын “Тэгш дүүрэн” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар тогтоосон 1 төлбөрийн акт бүрэн хэрэгжиж, өгсөн 2 зөвлөмжийн 1 нь бүрэн хэрэгжиж, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмж хангалтгүй, тайлант онд давтагдсан байна.

Хүснэгт 5 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	3.8	1	3.8	0.0	0.0	100.0
Зөвлөмж	2	13.6	1	13.6	1	0.0	50.0
Нийт дүн	3	17.4	3	17.4	1	0.0	

/сая төгрөг/

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 73.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 73.4 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 73.4 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 4.5 сая төгрөгийн түвшнээс 68.9 сая төгрөгөөр их хэдий ч санхүүгийн тайланд нөлөөлөлгүй тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй болно.

8.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

8.3 Албан шаардлага

8.3.1. Тайлант онд Цогтцэций сумын засаг даргатай “Тэгш дүүрэн” ОНӨААТҮГ-ын захирал 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг батлуулж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй". Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

8.3.2. Shilendans.gov.mn цахим хуудсанд 146 мэдээлэл байршуулахаас тухай бүр 1, улирал бүр 1 нийт 2 мэдээлэл хоцроож, бүтэн жил 2 мэдээлэл мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага,

төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 заалтууд, эрх, үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өгсөн өмнөх онд зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтсан тул албан шаардлага өгөх.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өглөг данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 4.2 сая төгрөгөөр авлага, 0.1 сая төгрөгийн өглөг нэмэгдсэн

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д: “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заалтуудыг мөрдөж ажиллах

2. Урт хугацаат өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд элэгдлийн дүнгээс тооцож бүртгэх үнэ төлбөргүй орлогыг борлуулалтын орлогоор бүртгэж тайлагнасан. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 “ нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Санхүүгийн тайлагналын “Ангилал” батламж мэдэгдлийн “ажил гүйлгээ, үйл явдлыг зөв дансанд ангилж бүртгэсэн байх гэсэнтэй нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Орлого, зарлагын ажил гүйлгээг үнэн зөв ангилж бүртгэх.

3. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн зардлын дүн ХХОАТ-ын тайлан /ТТ-11/ -ийн тайлан дахь дүнгээс илүү илэрхийлэгдсэн. Цалингийн зардлаас бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлсийг гаргасан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2. "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэснийг тайлагнаагүй тул залруулга хийлгэх гэснийг мөрдөөгүй

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасныг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/																
д/д	Байгуулагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	"Тэгш дүүрэн" ОНӨААТҮГ	ӨМА-2022/23/-НА-СТА-ОНӨААН	Тайлант онд сумын Засаг даргатай “Тэгш дүүрэн” ОНӨААТҮГ-ын захирал 2021 оны бизнес төлөвлөгөөг батлуулж ажиллаагүй.	Холбогдох эрх бүхий албан тушаалтантай гэрээ байгуулан, үйл ажиллагааны зорилтот төвшинг батлуулж ажиллах	1	0.0						1	0.0			
2			Тайлант онд 4.2 сая төгрөгөөр авлага, 0.1 сая төгрөгийн өглөг нэмэгдсэн	Авлага, өглөг үүсгэхгүй зардлыг зохистой зарцуулж байх.	1	4.3							1	4.3		
3			Тайлант онд үндсэн хөрөнгийн элэгдлээр тооцох орлогыг борлуулалтын орлогоор бүртгэж тайлагнасан.	Орлого, зарлагын ажил гүйлгээг үнэн зөв ангилж бүртгэх.	1	66.0							1	66.0		
4			Цалингийн зардлын дүн ХХОАТ-ын тайлан /ТТ-11/ -ийн тайлан дахь дүнгээс илүү илэрхийлэгдсэн Цалингийн зардлаас бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлсийг гаргасан	Ажил гүйлгээг данс бүртгэлд зөрүүтэй илэрхийлэх..	1	3.1							1	3.1		
ДҮН					4	73.4						1	0.0		3	73.4
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал																
5			Shilendans.gov.mn цахим хуудсанд 146 мэдээлэл байршуулахаас тухай бүр 1, улирал бүр 1 нийт 2 мэдээлэл хоцроож, бүтэн жил 2 мэдээлэл мэдээлээгүй байна.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжүүлж ажиллах	1	0.0						1	0.0			
			ДҮН		1							1	0.0			
			Нийт дүн		5	73,4						2	0.0		3	73,4